

# COVID-19

## Өөрийгөө тусгаарлахтай холбоотой өөрчлөлт



Хэрвээ та COVID-19-н шинжилгээгээр эерэг хариу авсан бол өөрийгөө тусгаарлах шаардлагагүй, харин танд илэрч буй цочмог шинж тэмдгүүд (нусгайрах, хоолой хөндүүрлэх, ханиалгах болон халуурах) арилтал гэртээ байхыг зөвлөж байна.

Хэрвээ та гэрээсээ гарах шаардлагатай бол:

- Дотор орчинд болон нийтийн тээврээр зорчихдоо амны хаалт зүүгээрэй
- Том хэмжээний цуглаан болон дотор орчинд хөл хөдөлгөөн ихтэй газарт очихоос зайлсхийгээрэй
- Хамгийн багадаа 7 хоногийн турш эмнэлэг, өндөр настны болон хөдөлмөрийн бэрхшээлтэй иргэдийн асрах газарт байгаа хүндээр өвчлөх эрсдэл өндөртэй хүмүүс дээр зочилж болохгүй.
- Ажилдаа хэзээ буцаж орох тухайгаа ажил олгогчтойгоо ярилцаарай.

Хэрвээ танд ханиад эсвэл томууны [шинж тэмдгүүд](#) илэрсэн бол гэртээ байж, [шинжилгээ хийлгээрэй](#). Хэрвээ та COVID-19 [вирусын эсрэг эмнүүдийг](#) хэрэглэх боломжтой бол шинж тэмдэг илэрсэн даруйдаа эхлээд шинжилгээ өгөх нь чухал юм. COVID-19-н шинжилгээгээр сөрөг хариу авсан ч биеийн байдал тавгүй үедээ гэртээ байх хэрэгтэй ба ингэснээр та ойр дотны болон эргэн тойрныхоо хүмүүст халдвар тараахаас сэргийлэх юм.

Хэдийгээр эсрэг биеийн түргэвчилсэн шинжилгээний эерэг хариугаа заавал бүртгүүлэх шаардлагагүй ч NSW Health байгууллагаас шинжилгээний хариугаа NSW Health-д бүртгүүлэхийг зөвлөж байгаа ба ингэснээр эрүүл мэндийн болон бусад тусламж үйлчилгээ авах боломжтой болно.

**Хэрвээ та эрүүл мэндийн ямар нэгэн асуудалтай бөгөөд хэлний туслалцаа хэрэгтэй бол Орчуулгын болон Хэлмэрчийн Үйлчилгээ (TIS) болох 131450 дугаарт залган 1800 022 222 дугаараар Healthdirect-тай холбож өгөхийг хүсээрэй.**